**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/26/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас: 70432545
цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....8

3. Аудитын тайлан....9

3.1 Ерөнхий зүйл ....9

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....10

3.4 Материаллаг байдал ....10

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....11

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....12

3.8 Аудитын гол асуудал ....12

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....12

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....13

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....13

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....13

4. Аудитын илрүүлэлт ....13

4.1 Залруулсан алдаа....13

4.2 Төлбөрийн акт....13

4.3 Зөвлөмж ....13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....13


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |

## 1.Аудитын санал, дүгнэлт

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84300 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70423061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Б.АЛТАНБАДРАЛТ ТАНАА

2022.02.16 № 2/32
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

0210202?8

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **994,243,945.63** | **1,379,132,597.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 6,328,433.60 | 435,470.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 395,470.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 6,200,420.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 128,013.60 | 40,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 128,013.60 | 40,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 987,915,512.03 | 1,378,697,127.63 |
| **351** | **Түүхий эд материал** | 653,019,084.03 | 885,834,083.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 617,618,854.03 | 669,398,903.03 |
| 35130 | Эм боох материал | 35,400,230.00 | 216,435,180.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 333,926,428.00 | 490,893,044.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,178,425.00 | 1,393,125.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 50,337,559.00 | 43,613,059.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,175,000.00 | 1,926,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 12,790,000.00 | 11,089,900.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,709,200.00 | 495,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 127,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 265,736,244.00 | 432,248,460.00 |
| 35600 | Мал амьтад | 970,000.00 | 1,970,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,029,201,785.25** | **7,307,384,684.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,029,201,785.25 | 7,307,384,684.23 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,508,868,785.25 | 6,787,051,684.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,947,771,649.00 | 2,959,771,649.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -192,763,694.43 | -205,283,650.73 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 4,679,322,465.33 | 5,714,442,465.33 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,175,352,366.39 | -1,913,565,901.81 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 436,544,202.68 | 437,259,538.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -224,770,275.64 | -311,926,246.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 65,536,523.13 | 70,930,832.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -33,892,620.10 | -40,140,019.56 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 15,560,000.00 | 15,560,000.00 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | -10,183,333.33 | -15,560,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,343,735.00 | 2,343,735.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,247,500.00 | -1,780,717.64 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 75,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 520,333,000.00 | 520,333,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,100,000.00 | -1,100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 520,333,000.00 | 520,333,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,023,445,730.88** | **8,686,517,281.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,560,918.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 8,560,918.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 8,560,918.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 8,560,918.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 8,560,918.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,014,884,812.88** | **8,686,517,281.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 8,014,884,812.88 | 8,686,517,281.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,074,993,693.17 | 1,074,993,693.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,074,993,693.17 | 1,074,993,693.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 5,828,315,192.24 | 6,499,984,951.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,828,315,192.24 | 5,824,703,156.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 675,281,794.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,111,575,927.47 | 1,111,538,637.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,023,445,730.88** | **8,686,517,281.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,907,110,417.00** | **6,028,675,272.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,514,661,444.00** | **1,366,008,032.99** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,471,065,822.00 | 1,366,008,032.99 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,471,065,822.00 | 1,366,008,032.99 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,471,065,822.00 | 1,366,008,032.99 |
| **122** | **Тусламжийн орлого** | 43,595,622.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 43,595,622.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,392,448,973.00** | **4,662,667,239.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,090,537,400.00 | 3,138,275,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,090,537,400.00 | 3,138,275,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 301,911,573.00 | 1,524,391,539.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,110,873.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 105,204,500.00 | 1,403,979,689.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 185,256,200.00 | 116,166,850.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,340,000.00 | 4,245,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,961,172,263.28** | **5,353,393,477.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,961,172,263.28** | **5,353,393,477.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,951,843,643.28 | 5,352,077,477.69 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,471,154,288.00 | 2,682,287,065.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,577,181,000.00 | 1,581,250,778.00 |
| 210102 | Нэмэгдэл | 838,874,700.00 | 1,040,193,768.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,098,588.00 | 60,842,519.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,603,958.00 | 72,222,290.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,422,658.00 | 6,128,421.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,101,000.00 | 1,667,244.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,680,800.00 | 1,333,795.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 420,200.00 | 342,686.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,979,300.00 | 62,750,142.19 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 200,758,730.00 | 148,441,992.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,370,092.00 | 32,079,110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 158,650,139.00 | 105,990,886.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,738,499.00 | 10,371,996.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 181,486,145.78 | 98,600,575.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,716,625.00 | 10,326,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,150,526.00 | 74,722,983.99 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,963,730.00 | 492,588.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 128,655,264.78 | 13,058,804.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 238,936,050.00 | 172,423,325.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,536,650.00 | 46,051,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 106,277,600.00 | 126,371,525.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 62,121,800.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,410,648.00 | 34,966,231.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,410,648.00 | 34,966,231.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,166,300.00 | 5,166,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,166,300.00 | 5,166,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,793,065.00 | 6,644,475.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,411,200.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,152,625.00 | 3,217,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,103,155.00 | 938,242.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 528,000.00 | 590,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,550,978.00 | 1,332,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,047,107.00 | 566,533.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 751,534,458.50 | 2,131,325,223.70 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 65,000.00 | 1,860,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 456,896,285.50 | 848,465,165.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,328,620.00 | 1,316,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,650,000.00 | 1,316,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,650,000.00 | 1,316,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 478,200.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 478,200.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,200,420.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,200,420.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,945,938,153.72** | **675,281,794.80** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,945,938,153.72** | **675,281,794.80** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,074,993,693.17 | 1,043,828,149.03 | 3,166,465,965.30 | 5,285,287,807.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 42,420.33 | 42,420.33 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,074,993,693.17** | **1,043,828,149.03** | **3,166,508,385.63** | 5,285,330,227.84 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -297,441,953.90 | -297,441,953.90 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,074,993,693.17** | **1,111,575,927.47** | **5,828,315,192.24** | 8,014,884,812.88 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,074,993,693.17** | **1,111,575,927.47** | **5,828,315,192.24** | 8,014,884,812.88 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -3,612,035.82 | -3,612,035.82 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,074,993,693.17** | **1,111,575,927.47** | **5,824,703,156.42** | 8,011,272,777.06 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -37,290.00 | 00.00 | -37,290.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 675,281,794.80 | 675,281,794.80 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,074,993,693.17** | **1,111,538,637.47** | **6,499,984,951.22** | 8,686,517,281.86 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,436,425,595.00** | **4,668,867,659.50** |
| **122** | **Тусламжийн орлого** | 43,595,622.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 43,595,622.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,392,829,973.00** | **4,668,867,659.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,090,537,400.00 | 3,138,275,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,090,537,400.00 | 3,138,275,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 302,292,573.00 | 1,530,591,959.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,491,873.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 105,204,500.00 | 1,403,979,689.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 185,256,200.00 | 116,166,850.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,340,000.00 | 4,245,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,368,995,595.00** | **4,581,867,659.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,368,995,595.00** | **4,581,867,659.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,353,266,975.00** | **4,573,601,759.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,465,011,200.00 | 2,677,928,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,577,181,000.00 | 1,589,818,632.00 |
| 210102 | Нэмэгдэл | 838,874,700.00 | 1,040,193,768.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 48,955,500.00 | 47,916,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,140,600.00 | 73,612,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,959,300.00 | 5,600,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,101,000.00 | 1,550,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,680,800.00 | 1,240,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 420,200.00 | 310,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,979,300.00 | 64,911,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 182,471,500.00 | 156,187,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 34,564,700.00 | 27,423,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 128,954,100.00 | 121,870,904.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,952,700.00 | 6,893,496.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 62,794,600.00 | 39,244,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,696,000.00 | 2,696,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 58,030,700.00 | 35,005,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,067,900.00 | 1,542,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 96,260,100.00 | 112,203,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 843,500.00 | 843,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 95,236,000.00 | 111,360,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 180,600.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 143,544,300.00 | 25,498,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 135,020,900.00 | 4,133,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,523,400.00 | 21,365,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,166,300.00 | 5,166,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,166,300.00 | 5,166,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,348,800.00 | 10,894,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 933,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,217,500.00 | 3,217,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,094,000.00 | 3,094,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 496,000.00 | 496,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,217,800.00 | 2,217,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,390,500.00 | 1,868,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 311,529,575.00 | 1,472,866,359.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,935,200.00 | 8,524,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,728,620.00** | **8,265,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,050,000.00 | 8,265,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 8,265,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,050,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 478,200.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 478,200.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,200,420.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,200,420.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **67,430,000.00** | **87,000,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **67,430,000.00** | **87,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **67,430,000.00** | **87,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 67,430,000.00 | 87,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 67,430,000.00 | 87,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-67,430,000.00** | **-87,000,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,138,275,700.00 | 3,138,275,700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,138,275,700.00 | 3,138,275,700.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,130,009,800.00 | 3,130,009,800.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,677,928,400.00 | 2,677,928,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,570,987,500.00 | 1,589,818,632.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,059,024,900.00 | 1,040,193,768.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,916,000.00 | 47,916,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,612,500.00 | 73,612,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,000,000.00 | 5,600,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,550,400.00 | 1,550,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,240,300.00 | 1,240,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 310,200.00 | 310,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 67,511,600.00 | 64,911,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 156,187,700.00 | 156,187,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 27,423,300.00 | 27,423,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 115,197,700.00 | 121,870,904.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,566,700.00 | 6,893,496.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,244,100.00 | 39,244,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,696,000.00 | 2,696,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,005,200.00 | 35,005,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,542,900.00 | 1,542,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 112,203,500.00 | 112,203,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 843,500.00 | 843,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 111,360,000.00 | 111,360,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,498,900.00 | 37,498,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,133,000.00 | 4,133,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,365,900.00 | 33,365,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,166,300.00 | 5,166,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,166,300.00 | 5,166,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,894,000.00 | 10,894,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,217,500.00 | 3,217,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,094,000.00 | 3,094,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 496,000.00 | 496,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,217,800.00 | 2,217,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,868,700.00 | 1,868,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8524400.00 | 8524400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,524,400.00 | 8,524,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8265900.00 | 8265900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,265,900.00 | 8,265,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 8,265,900.00 | 8,265,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,138,275,700.00 | 3,138,275,700.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,138,275,700.00 | 3,138,275,700.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,138,275,700.00 | 3,138,275,700.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0 | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 195 | 195 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 173 | 173 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 20 | 20 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **195** | **195** |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 175 | 175 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 12 | 12 |
| 650010 | Гэрээт ажилтан | 8 | 8 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **339,687,775.00** | **1,530,591,959.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **301,687,775.00** | **1,530,591,959.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 301,687,775.00 | 1,530,591,959.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 301,687,775.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 301,687,775.00 | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **38,000,000.00** | **00.00** |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 38,000,000.00 | 00.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 339,683,775.00 | 1530591959.50 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 339,683,775.00 | 1,530,591,959.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,491,873.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 142,599,702.00 | 1,403,979,689.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 185,252,200.00 | 116,166,850.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,340,000.00 | 4,245,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 6,200,420.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун бүсийн төв Ховд аймгийн онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 02 дугаар сарын 07-ноос 2022 оны 02 дугаар сарын 16–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 35/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Онцгой байдлын газар нь “Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг

хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Гамшгаас хамгаалах мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх*
- *Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх замаар галын аюулгүй байдлыг хангах, гал түймэртэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах*
- *Улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулж, гамшгийн дараах үйл ажиллагааг эрчимжүүлэх*
- *Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтыг сайжруулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх*
- *Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацыг нэвтрүүлэх*
- *Харьяа дээд газрын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Онцгой байдлын ерөнхий газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 6,028.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 60.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 42.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Онцгой байдлын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 663.1 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өмчийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.4 сая сая төгрөг болж 5.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайланд онд өнгөрсөн жилийн 6.2 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага бүрэн барагдуулж тайлант онд татварын авлага 0.4 сая төгрөгийн авлага бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,378.7 сая төгрөг болж 390.8 сая төгрөгөөр буюу 39.5 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 755.5 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр 320.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 685.0 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8,668.5 сая төгрөг, оны эцэст 9,796.7 сая төгрөг болж 1,128.2 сая төгрөгөөр өссөн нь Онцгой байдлын ерөнхий газраас 1,035.1 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлсэн, Азийн хөгжлийн банк японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр гамшгийн эрсдэлийн үнэлгээ төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх техник туслалцааны төслөөс 10.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлж Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 180.0 сая төгрөгийн өртөгтэй 6 автомашины тавиулан баригдахаас тайлант онд 75.0 сая төгрөгийн хөрөнгийг тус байгууллагад шилжүүлэн дуусаагүй барилгаар бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 12.0 сая төгрөгийн их засварын ажлыг капиталжуулж 4.4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж тайлант оны хуримтлагдсан элэгдэл 848.5 сая төгрөг байгаатай холбоотой байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 8.6 сая төгрөгийн өглөг бүрэн барагдаж оны эцэст өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8,014.9 сая төгрөг байсан оны эцэст 8,686.5 мянган төгрөг болж тайлант онд 671.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хуримтлагдсан элэгдлийн зөрүү 6.0 сая төгрөг, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 0.03 сая төгрөг, өглөгөөр бүртгэсэн 2.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө нь тухайн байгууллагын дансаар дамжихгүйгээр шууд байгууллагын дансанд орсонтой холбоотой залруулах бичилт хийсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 6,450.0 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Онцгой байдлын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,138.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,138.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 3,138.3 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3,138.3 сая төгрөгийн төсөв батлснаас 3,138.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,138.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,138.3 сая мянган төгрөгийг зарцуулж нийт зардлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Хөшөөт хөгжил сангаас 6 машины тавиулан барихтай холбоотой 75.0 сая төгрөг Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 1,404.0 сая төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 116.2 сая төгрөг, нэмэлт үйл ажиллагааны хүрээнд 4.2 сая төгрөг, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагаас 6.2 сая төгрөг нийт 1530.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,530.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах асуудал байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалт аймагт бүртгэгдсэнтэй холбоотойгоор халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Онцгой комисс, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, албан байгууллага, аж ахуйн нэгж 16 сумаас 1,404.0 сая төгрөгийн зардлыг бүртгэж тайлагнасан байна. Цар тахалтай холбоотойгоор 8 газарт ойрын хавьталд орсон иргэдийг тусгаарлах байр байгуулж 8,820 хүнийг хамруулж 218.8 сая төгрөгийг байрны зардалд, хоолны зардалд 119.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн онцгой комисст 8 иргэн, аж ахуйн нэгж 15.7 сая төгрөгийн бараа материалыг хандивласан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс 162 мэдээллийг хугацаандаа оруулсан, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илэрсэнгүй.

### 4.1 Залруулсан алдаа

1. Аудитаар залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт, албан шаардлага бичигдээгүй

### 4.3 Зөвлөмж

Тус байгууллагад хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Аудитаар алдаа илрээгүй болно.

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**